



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

᠑᠙81 оны ᠐᠘ сарын 28 өдөр

Дугаар А/1᠖᠘

Мандалговь

Дуудлага худалдаа зохион байгуулах
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус аймгийн Сайнцагаан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 12 тоот тогтоолоор батлагдсан 2021 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу иргэн, аж ахуй нэгж байгууллагад худалдаа үйлчилгээ, амины орон сууцны зориулалтаар шинээр эзэмшүүлэх газрын дуудлага худалдаа явуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Газрын удирдлагын хэлтсийн дарга (Б.Рэнцэндорж)

Хөтлөгч: Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Газрын төлбөр, үнэлгээ, татварын асуудал хариуцсан мэргэжилтэн (Д.Болорчимэг)

Тэмдэглэл хөтлөгч: Сайнцагаан сумын Газрын даамал (Л.Хулан)

2. Газар эзэмших эрхийн дуудлага худалдаа явуулах ажлын журам, зааврыг баримтлан ил тод, нээлттэй явуулахыг ажлын хэсгийн дарга (Газрын удирдлагын хэлтсийн дарга)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210440